



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 820

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 70,394,110.00 (далан сая гурван зуун ерэн дөрвөн мянга нэг зуун арав) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ж.Чойхандад Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай;

3.“Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Ж.Чойханд)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2.Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/09 дугаар тушаалын дагуу “Байгаль орчны судалгаа шинжилгээний төв” улсын төсөвт үйлдвэрийн газартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний заалтыг зөрчиж, зориулалт бусаар санхүүжүүлсэн 2,740,400.00 (Хоёр сая долоон зуун дөчин мянга дөрвөн зуун) төгрөгийг “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дансанд буцаан төвлөрүүлэх;

3.3.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

4.Тогтоолын биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн  
270 дугаар тогтоолын хавсралт



“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА, ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ  
ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ  
АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн (төгрөг/)	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Хамтын гэрээний үүргийг зөрчиж, санхүүжилт олгосон. (аяны хэрэгслэл)	18,435,000.00	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д зааснаар “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах -мөрдөж ажиллах.
2	Хамтын гэрээний үүргийг зөрчиж, санхүүжилт олгосон. (автомашинны сэлбэг хэрэгслэл)	4,225,000.00	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д зааснаар “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах- мөрдөж ажиллах.
3	Зориулалтын зардлаар дурсгалын худалдан талаар бус бэлэг зүйлс авсан	2,740,380.00	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5-д “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах хориглоно” - мөрдөж ажиллах.
4	Батлагдсан зардлын төлөвлөгөөнд тусгагдаагүй байгууллагын албан хаагчдад унааны зардал олгосон талаар	1,124,000.00	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.- мөрдөж ажиллах.
5	Зөвшөөрөлгүйгээр хөрөнгө бүртгэсэн зөрчлийн талаарх зөрчлийн талаар	43,869,730.00	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам” 271 дүгээр журмыг мөрдөж ажиллах.
НИЙТ ДҮН		70,394,110.00	(далан сая гурван зуун ерөн дөрвөн мянга нэг зуун арав)